**ХУУЛЬ ЗҮЙН**
**ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

# ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| | |
|---|---|
| ТАНИЛЦСАН:<br>ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД<br>ХЭРГИЙН САЙД | Төсвийн ерөнхийлөн захирагч<br><br>/........................................./ Б.ЭНХБАЯР |
| ТАЙЛАГНАСАН:<br>ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ<br>ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ | Төсвийн шууд захирагч<br><br>/........................................./ Н.ЖАМЪЯНХҮҮ |

2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| № | Үндсэн чиг үүрэг | | Арга хэмжээний тоо | Хуудасны дугаар |
|---|---|---|---|---|
| 1 | Зорилт 1. Байгууллагын хүний нөөц чадавхыг бэхжүүлэх, мэргэшүүлэх, хөгжүүлэх тогтолцоог сайжруулах | | 11 | 2-8 |
| 2 | Зорилт 2. Хууль зүйн бодлогод эрдэм шинжилгээ, судалгааны ажлаар дэмжлэг үзүүлэх, гадаад харилцаа хөгжүүлэх | 2.1. Эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн эрх зүйн салбарын нийтлэг харилцааг зохицуулдаг хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт тогтмол үнэлгээ хийх | 8 | 8-10 |
| | | 2.2. Хуулийн төсөл боловсруулах ажилд суурь, хавсарга болон харьцуулсан судалгаа, лавлагаа, бусад мэдээллээр дэмжлэг үзүүлэх | 2 | 10-12 |
| | | 2.3. Гадаад орнуудын хууль тогтоомж, хууль зүйн ном бүтээлийг орчуулж нийтийн хүртээл болгох | 1 | 12 |
| | | 2.4. Судалгааны арга зүйгээр мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх | 2 | 12 |
| | | 2.5. Эрх зүйн гол салбарт хийгдэж буй суурь судалгааны үр дүнг нэгтгэн жил бүр хэвлүүлэх | 1 | 13 |
| | | 2.6. Гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид, хуульчдын дунд хууль зүйн салбарын мэдээлэл солилцох, туршлага хуваалцах, мэтгэлцэх орчин бүрдүүлж, эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, семинар зохион байгуулах | 7 | 13-16 |
| | | 2.7. Гадаад улсын болон дотоодын ижил төрлийн чиг үүрэг бүхий байгууллагатай харилцаа тогтоож, хамтран ажиллах | 1 | 16-17 |
| 3 | Зорилт 3. Хууль зүйн судалгааны бүтээл, эх сурвалжийг багтаасан орчин үеийн жишигт нийцсэн цахим платформ хөгжүүлэх | | 3 | 17-18 |
| 4 | Зорилт 4. Хууль зүйн хэлний зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагааны тасралтгүй үр дүнтэй байдлыг хангах | | 2 | 18-19 |
| 5 | Зорилт 5. Хууль зүйн албан бус сургалтын үйл ажиллагааг шат дараатай өргөжүүлэх | | 5 | 19-21 |
| 6 | Зорилт 6. Хууль тогтоомжийг олон нийтэд хүртээмжтэй арга хэлбэрээр хүргэх | | 15 | 21-28 |
| **Нийт** | | | **58** | 28 |

*Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 01/553 тоот албан бичгийн нэгдүгээр хавсралт*

# ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|---|
| ЗОРИЛГО. ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГОД ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖЛААР ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ХУУЛЬ ЗҮЙН НЭР ТОМЬЁОГ ОНООН ТОДОРХОЙЛОХ, ЖИГДЛЭХ, ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХ ЗҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ИРГЭД, ОЛОН НИЙТЭД ТОГТМОЛ ХҮРГЭХ. | | | | | | | |
| ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ: ЗАХИРГАА, УДИРДЛАГА | | | | | | | |
| ЗОРИЛТ 1. Байгууллагын хүний нөөц чадавхыг бэхжүүлэх, мэргэшүүлэх, хөгжүүлэх тогтолцоог сайжруулах | | | | | | | |
| 1.1. | Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, албан хаагчдыг мэргэшүүлэх, хөгжүүлэх тогтолцоог сайжруулах. | Улсын төсөв | Магистрын зэрэгтэй албан хаагчийн тоог нэмэгдүүлсэн байх | 10 | 12 | Тус хүрээлэнд ажиллаж байгаа нийт албан хаагчдын 11 нь магистрын зэрэгтэй, одоо магистрантаар суралцаж буй 5 албан хаагч байна. Үүнээс: Дотоодод их сургуульд-1, Гадаад улс оронд их сургуульд -4 /Австралийн улсад 1, ХБНГУ-д 2, Япон улсад 1 албан хаагч/ | 95 |
| 1.2. | Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах. | Улсын төсөв | Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж үр дүнтэй ажилласан байна. | Тогтоосон хугацаанд ХЗДХЯ-нд хүргүүлсэн | Тогтоосон хугацаанд ХЗДХЯ-нд хүргүүлсэн байна. | *Хууль тогтоомжийн хүрээнд:* Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 44 дүгээр "Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай" зарлиг,<br>Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах арга хэмжээний тухай" 249 дүгээр тогтоол /Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн /Өргөтгөлийн/ барилга угсралтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлт/, Монгол Улсын Ерөнхий сайдын 01, 02, 03, 04 дүгээр албан даалгавар, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоол, Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 126 дугаар тогтоолуудыг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт /эхний хагас жил, III улирал/, Засгийн газрын 2023 оны 231 дүгээр тогтоолын дагуу "Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагаа"-ны 2023-2027 оны төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг тус тус гаргаж ХЗДХЯ-нд хүргүүлсэн.<br>Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний 23 дугаар тогтоолын дагуу Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг тус хүрээлэн дээр 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 13-ны өдрүүдэд явагдсан.<br>*Бодлогын баримт бичгийн хүрээнд:*<br>Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын биелэлтийг 1 дүгээр улирлын байдлаар,<br>Монгол Улсын Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоср батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг тус тус гарган Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан бичгээр хүргүүлж ажилласан. | |
| 1.3. | Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 71 дүгээр захирамжаар батлагдсан "Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө- /2024-2027/-нд тусгагдсан арга хэмжээнээс холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх. | Улсын төсөв | Арга хэмжээнээс холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх хувь | 100% | 100% | "Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө"-г 4 зорилт, 13 заалттай боловсруулж 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр захирлаар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан, эхний хагас жилийн тайланг 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 01/221 тоот албан бичгээр, 2025 оны тайланг 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/524 тоот албан бичгээр тус тус ХЗДХЯ-нд хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4. | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030 он/-т тусгагдсан арга хэмжээнээс холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх. | Улсын төсөв | Арга хэмжээнээс холбогдох үйл ажиллагааны хэрэгжилтийг бүрэн биелүүлсэн хувь | 100% | 100% | Тус хүрээлэнгийн ёс зүйн дэд хорооны хуралдаан 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулагдаж 2024 оны тайланг хэлэлцэж, 2025 онд хэрэгжүүлэх ажлыг 3 бүлэг, 11 хэсэгтэй төлөвлөж Ёс зүйн дэд хорооны дарга /Эрдэмтэн нарийн бичгийн дарга/ баталсан.<br>Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар тус хүрээлэнгийн ёс зүйн дэд хорооны гишүүнийг нөхөн сонгох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан нөхөн сонгох үйл ажиллагааг явуулсан. 2025 оны 07 дугаар сарын 09-ий өдрийн А/34 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хорооны тушаалд өөрчлөлт оруулсан. Тус дэд хороо 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр хуралдан нарийн бичгийн дарга сонгосон.<br>2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрүүдэд "Эерэг харилцаа-Эрүүл орчин", "Эрүүл бие-инээд баясал" аяныг нийт албан хаагчдын дунд эрүүл мэнд, биеийн дархлаа, сэтгэлийн эрүүл байдлыг дэмжих, инээд баясал, эерэг харилцааг нэмэгдүүлэх, ёс зүйн соёлыг бэхжүүлэх зорилгоор 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>"Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"/2024-2030/-ийн хэрэгжилтийг Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрээнд гаргаж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/403 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн.<br>Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хорооны гишүүн, доктор (Ph.D), дэд профессор М.Цэрэнбат 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд", "Стресс менежмент",<br>Filo Bianco LLC marketing seniour Kreativ Arc Studio& Agency Founder багш Б.Үенч 2025 оны 07 дугаар сарын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 04-ний өдөр" Харилцааны соёл ба хамт олны эрүүл орчин",<br>Ёс зүйн сургагч багш, "Далд оршихуй" НҮТББ-ын тэргүүн, хүний их эмч Б.Пүрэвжав 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр "Эрүүл оршихуй ба ёс зүй" сургалтыг тус тус орж нийт албан хаагчид хамрагдсан.<br>2025 оны 12 дугаар сарын 01-ээс 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрүүдэд Монгол Улсын Ёс зүйн хороо, Удирдлагын академийн хамтран зохион байгуулсан "Ёс зүйн сургагч багш бэлтгэх" сургалтад ёс зүйн дэд хорооны гишүүн, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга хамрагдаж, гэрчилгээ авсан. | |
| 1.5. | Байгууллагын гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх. | Улсын төсөв | Байгууллагын гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг журмын дагуу хийж, тогтоосон хугацаанд хүргүүлсэн тоо | 2 | 2 | Хүрээлэнгийн 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2025.06.13-ны өдрийн 01/266 тоот албан бичгээр,<br>2025 оны гүйцэтгэлийн тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 01/533 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| 1.6. | Архив, албан хэрэг хөтлөлтийн цахим хэлбэрээр хөтлөн, албан бичгийн эргэлтэд тавих хяналтыг сайжруулах. | Улсын төсөв | "E-doc" цахим системээр хөтөлсөн тоо | 100% | 100% | 2025 онд тус хүрээлэнд e-doc цахим системээр<br>- ирсэн албан бичиг 455<br>- явсан албан бичиг 450<br>- хугацаанд нь шийдвэрлэсэн 435,<br>- Судлагдаж байгаа 20 албан бичиг байна.<br>Нийт 925 бичиг эргэлтэд орж, хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн албан бичиг байхгүй. | 100 |
| 1.7. | Байгууллагын үйл ажиллагааны статистик мэдээ, инфографик мэдээг тухай бүр гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх. | Улсын төсөв | - Хүргүүлсэн мэдээллийн тоо | 12 | 12 | 2024 оны 12 дугаар сар, 2025 оны 1-11 дүгээр сарын статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яамны мэдээний маягтын дагуу 6 төрлийн 41 мэдээллийг сар бүр өссөн дүнгээр гаргаж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан бичгээр хүргүүлж ажилласан.<br>2025 оны инфографик мэдээг тухай бүр байгууллагын https://nli.gov.mn/ цахим хаягт байршуулан ажиллаж байна. | 100 |
| 1.8. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил | Улсын төсөв | - Төлөвлөгөөт ажлын хэрэгжилтийн хувь | 100% | 100% | "Монгол Улсын 2025 оны төсвийн хөрөнгөөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-д батлагдсан тус хүрээлэнгийн | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах. | | | | | ХЗҮХ/20250102001 дугаартай төслийн 837,2 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга бэлтгэх техникийн тодорхойлолтыг батлагдсан маягтын дагуу гарган Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж, №УТ2501201091 Төсөл, арга хэмжээний "Багц-1: Хурлын заалны тоног төхөөрөмж худалдан авах" бараа нийлүүлэлтийн гэрээг "Монтех дистрибьюшн" ХХК-тай 2025 оны 04 дүгээр сарын 24, "Багц-2: "ХЗҮХ-ийн өргөтгөлийн барилгын гадна болон дотор хэргүүрийн тоног төхөөрөмж худалдан авах" бараа нийлүүлэлтийн гэрээг "Ай Ти Скайвишн ворлд" ХХК-тай 2025 оны 05 дугаар сарын 23, "Багц-3: хурлын заал, өрөөнүүдийн тавилга, эд хогшил" худалдан "Санаа мед трейд" ХХК-тай 2025 оны 04 дүгээр сарын 24-ний, "Багц-4: компьютер, канон, номын скайнер" худалдан авах ажлын гэрээг "Би Си Ти" ХХК-тай 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрүүдэд тус тус гэрээ байгуулж, тус хүрээлэнгийн захирлын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүд тавилга, тоног төхөөрөмжүүдийг шалган, акт үйлдэн хүлээн авч үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаж, санхүүжилтийг бүрэн олгосон.<br>Тус хүрээлэнгээс байгуулагдсан 2 үнэлгээний хороо нь хүрээлэнгийн 2025 оны урсгал санхүүжилтээс санхүүжих, ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдсан ХЗҮХ/20250203009 ТШ-ын кодтой подкаст дохионы хэлмэрчийн үйлчилгээ үзүүлэх ажлыг "Дохионы хэлмэрч орчуулагчдын холбоо" НҮТББ-тай 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр ХЗҮХ/25/12 дугаартай гэрээ, ХЗҮХ/20250203003 ТШ-ын кодтой "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл", "Хууль дээдлэх ёс" сэтгүүл, Судалгааны тайлангийн эмхэтгэл ба бусад хэвлэх материалын хэвлэх үйлчилгээ гүйцэтгэх тендерийн ажлыг "Тоонот принт" ХХК-тай, 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр ХЗҮХ/25/11 дугаартай гэрээ байгуулж гэрээний гүйцэтгэлийг дүгнэх ажлын хэсгийг ХЗҮХ-ийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/57 дугаар тушаалаар байгуулан гэрээ дүгнэх ажлыг зохион байгуулж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.9. | Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем www.docx.gov.mn-ийг хэвшүүлэн ажиллах. | Улсын төсөв | Албан бичиг солилцооны дундын систем www.docx.gov.mn ашиглах үйлчилгээний нөхцөлийн дагуу ашиглаж хэвшсэн хувь | 100% | 100% | Албан бичиг солилцооны дундын систем (Docx)-ийг салбарын хэмжээнд нэвтрүүлэхээр үйлчилгээний нөхцөлийн дагуу бүртгүүлж, төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авах ажиллагааг хэвшүүлэн ажиллаж байна. | 100 |
| 1.10. | Шил ажиллагаа www.shilengov.mn цахим хуудсанд байгууллагын ил тод мэдээллийг байршуулах. Санхүүгийн мэдээллийг байгууллагын цахим хуудас болон www.shilendans.gov.mn цахим хуудсанд тогтмол байршуулж, олон нийтэд мэдээлэх. | Улсын төсөв | Хууль, журамд заасан хугацааны дотор тухай бүр | 100% | 100% | Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн 8 дугаар зүйлд заасан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт, үнэлгээг 2024 оны байдлаар гаргаж ХЗДХЯ-нд 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 02/53 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>ХЗДХЯ-ны 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 4/1493 тоот албан бичгийн дагуу хүрээлэнгийн 41 ил тод мэдээллийг байршуулж ажилласан.<br>2025 оны I улирлын мэдээллийг 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр, II улирлын мэдээллийг 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр, III улирлын мэдээллийг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр тус тус www.shilengov.mn цахим хуудсанд оруулж олон нийтэд мэдээлж ажилласан.<br>2025 оны 12 дугаар сарын 25-ны дотор www.shilengov.mn цахим хуудсанд жилийн эцсийн мэдээллийг оруулахаар ажиллаж байна.<br>2025 оны 1-11 дүгээр сарын санхүүгийн мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд нийт 163 мэдээллийг хугацаанд нь оруулсан.<br>Оруулах Оруулсан<br>Тухай бүр 110 110<br>Сар бүр 44 44<br>Хагас жил 4 4<br>Жил бүр 5 5 | 100 |
| 1.11. | Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулж | Улсын төсөв | Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, Тайланг хүргүүлсэн байна. | 1 | 1 | Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг 3 бүлэг, 9 хэсэгтэй 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр захирлаар батлуулж, тус төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: Хөдөлмөрийн дотоод журам, бусад | 85 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | батлуулах, төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх. | | | | | холбогдох журмын хэрэгжилт, ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдлын холбогдох стандартын хэрэгжилтийг хангах,<br>Хүрээлэнгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа автомашин, харилцаа холбоо, техник хэрэгсэл, гэрэл цахилгаан, барилга байгууламжийн аюулгүй байдал, бичиг баримтад үзлэг шалгалт хийх,<br>Хүрээлэнгийн захирлын тушаалаар 2024, 2025 онд байгуулагдсан ажлын хэсгийн тушаалын хэрэгжилт, захирлын 2025 оны А/01-А/43 дугаар тушаалын хэрэгжилтийг гаргах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн захиргааны зөвлөлийн хуралд танилцуулсан. Шинэ байранд нүүж орсонтой холбогдуулан харуулуудад хоногийн мэдээний бүртгэлийг мөрдүүлж, ажиллаж байна.<br>Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 9/2415 дугаартай албан бичгийн дагуу Дотоод хяналт шалгалтын тайлан, холбогдох мэдээг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 01/554 тоот албан бичгээр хүргүүлсэн. | |
| Хэсгийн дундаж 97.7 % | | | | | | | |
| ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ: ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГЫН СУУРЬ, ХАВСАРГА БОЛОН БУСАД СУДАЛГАА ХИЙХ, АРГА ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ | | | | | | | |
| ЗОРИЛТ 2. Хууль зүйн бодлогод эрдэм шинжилгээ, судалгааны ажлаар дэмжлэг үзүүлэх, гадаад харилцаа хөгжүүлэх | | | | | | | |
| 2.1. Эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн эрх зүйн салбарын нийтлэг харилцааг зохицуулдаг хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт тогтмол үнэлгээ хийх | | | | | | | |
| 2.1.1. | Эрүүгийн эрх зүйн салбарын нийтлэг харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх (материаллаг эрх зүй) | Улсын төсөв | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу үнэлгээ хийсэн тайлангийн тоо | 1 | 1 | "Өмгөөллийн урамтай нүүдэл консалтинг" ХХК-тай 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан гэрээний үндсэн дээр "Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйлд заасан үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтэд хийсэн үнэлгээ" сэдвээр судалгаа гүйцэтгүүлж, тайланг 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 01/286 дугаартай албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. | 100 |
| 2.1.2. | Эрүүгийн эрх зүйн салбарын нийтлэг харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр | Улсын төсөв | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу үнэлгээ хийсэн | 1 | 1 | "Алтан гэрэгэ" ТББ-тай 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан гэрээний үндсэн дээр "Эрүүгийн процессын эрх зүй дэх шүүхийн шийтгэх тогтоолын үндэслэл, хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал" сэдвээр судалгаа гүйцэтгүүлж, тайланг 2025 оны 06 дугаар сарын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дагаварт үнэлгээ хийх (процессын эрх зүй) | | тайлангийн тоо | | | 30-ны өдрийн 01/302 дугаартай албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. | |
| 2.1.3. | Иргэний эрх зүйн салбарын нийтлэг харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх (материаллаг эрх зүй) | Улсын төсөв | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу үнэлгээ хийсэн тайлангийн тоо | 1 | 1 | Компанийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгаа гүйцэтгэж, тайланг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 01/299 дугаартай албан бичгээр, Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 115 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэгт оролцож Иргэний хуулийн Ерөнхий ангийн Найм, Есдүгээр бүлгийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, тайланг Улсын Их Хурлын тамгын газарт хүргүүлсэн. | 100 |
| 2.1.4. | Иргэний эрх зүйн салбарын нийтлэг харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх (процессын эрх зүй) | Улсын төсөв | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу үнэлгээ хийсэн тайлангийн тоо | 1 | 1 | "Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ" сэдвээр судалгаа гүйцэтгэж, тайланг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 01/298 дугаартай албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. | 100 |
| 2.1.5. | Захиргааны эрх зүйн салбарын нийтлэг харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх (материаллаг эрх зүй) | Улсын төсөв | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу үнэлгээ хийсэн тайлангийн тоо | 1 | 1 | "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ" сэдвээр судалгаа гүйцэтгэн, тайланг ХЗДХЯ-нд 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 01/295 дугаартай албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн.<br>"Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ" сэдвээр судалгаа гүйцэтгэн, тайланг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 01/236 дугаартай албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. | 100 |
| 2.1.6. | Захиргааны эрх зүйн салбарын нийтлэг харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх (процессын эрх зүй) | Улсын төсөв | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу үнэлгээ хийсэн тайлангийн тоо | 1 | 1 | "Лэгис энд Эй Ай" ХХК-тай гэрээ байгуулсны үндсэн дээр "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ" сэдвээр судалгаа гүйцэтгүүлсэн.<br>Судалгааны тайланг хянаж, дүгнэлт, санал боловсруулан 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр гүйцэтгэгч талд хүргүүлсэн. "Лэгис энд Эй Ай" ХХК-аас холбогдох засварын дагуу сайжруулж ирүүлсэн тайланг | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ХЗДХЯ-нд хүргүүлнэ. | |
| 2.1.7. | Зөрчлийн тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх | Улсын төсөв | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу үнэлгээ хийсэн тайлангийн тоо | 1 | 1 | Зөрчлийн тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны ажлыг гүйцэтгэн, тайланг 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 01/294 дугаартай албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн. | 100 |
| 2.1.8. | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх | Улсын төсөв | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу үнэлгээ хийсэн тайлангийн тоо | 1 | 1 | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгаа гүйцэтгэсэн. Судалгааны тайланг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ХЗДХЯ-нд хүргүүлнэ. | 95 |
| 2.2. Хуулийн төсөл боловсруулах ажилд суурь, хавсарга болон харьцуулсан судалгаа, лавлагаа, бусад мэдээллээр дэмжлэг үзүүлэх | | | | | | | |
| 2.2.1. | Хууль зүй, дотоод хэргийн яамнаас иргүүлсэн захиалгын дагуу цаг үеийн шинжтэй судалгаа, лавлагаа хийх. | Улсын төсөв | Тухай бүр | 100% | 100% | Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу "Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийн үр нөлөө", "Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ", Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан 22 хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах,<br>ХЗДХЯ-ны 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 3/313 тоот албан бичгийн дагуу: Эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хавтаст хэргийг цахимжуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч байгууллагуудын цахим мэдээллийн санг нэгтгэн холбох, цахим системийн ашиглалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангахтай холбоотой хуулийн төслийг боловсруулахтай холбогдох судалгаа, "Эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж тайлбар, мэдүүлэг авсан нь тухайн хүнийг яллах эх сурвалж болохгүй байх зохицуулалт ба | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | олон улсын гэрээний нийцэл бүхий хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах судалгаа" зэрэг 14 судалгаа,<br>Жендэрийн салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг хангах хүрээнд: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ /Хууль зүйн салбараас бусад салбарын хууль тогтоомжид жендэрийн тодорхой зохицуулалт тусгасан эсэх, тусгах шаардлагатай эсэх/, /Жендэрийн хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага/, /Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад олон нийтийн байгууллагын оролцоо/ зэрэг 4 судалгаа,<br>Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хуулийн төслийн хүрээнд: Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хуулийн төслийн зардлын тооцоо, "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ" сэдвүүдээр судалгааг тус тус гүйцэтгэн, тайланг ХЗДХЯ-нд албан бичгээр хүргүүлсэн.<br>Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгын дагуу "Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ" зэрэг 8 судалгааг гүйцэтгэсэн бөгөөд тайланг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ХЗДХЯ-нд хүргүүлэхээр ажиллаж байна.<br>ХЗДХЯ-ны 2025 оны 11 дүгээр сарын 24-ний 3/2389 дугаартай албан бичгийн дагуу 2 багц судалгааг гүйцэтгэх удирдамж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. | |
| 2.2.2. | Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх хүрээнд судалгаа, лавлагаа гүйцэтгэх (Авлигатай тэмцэх хөтөлбөр) | Улсын төсөв, бусад эх үүсвэр | Судалгааны тайлангийн хувь | - | 4 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд заасны дагуу:<br>"Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ" сэдвээр судалгаа гүйцэтгэн, тайланг ХЗДХЯ-нд 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 01/295 дугаартай албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн;<br>"Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ" сэдвээр судалгаа гүйцэтгэсэн. Судалгааны | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тайланг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ХЗДХЯ-нд хүргүүлнэ. | |
| 2.3. Гадаад орнуудын хууль тогтоомж, хууль зүйн ном бүтээлийг орчуулж нийтийн хүртээл болгох | | | | | | | |
| 2.3.1. | Гадаад орнуудын хууль тогтоомж, хууль зүйн ном бүтээл орчуулж хэвлүүлэх. | Улсын төсөв | -Гадаад орнуудын хууль тогтоомж, хууль зүйн ном бүтээл орчуулан хэвлүүлж, олон нийтэд хүргэсэн байх. | 1 | 1 | МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор Б.Буянхишигтэй 24/06 дугаартай "Ажил гүйцэтгэх гэрээ" байгуулж, ХБНГУ-ын "Эрүүгийн процессын хууль" орчуулах ажлыг гүйцэтгүүлсэн. 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор нийтийн хүртээл болгохоор ажиллаж байна. | 85 |
| 2.4. Судалгааны арга зүйгээр мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх | | | | | | | |
| 2.4.1. | Судалгааны арга зүйн сургалт, семинар, уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах, судлаачдыг хамруулах | Улсын төсөв | Хамрагдсан хүний тоо | 20 | 20-оос доошгүй | БНСУ-ын Хууль тогтоомжийн судалгааны хүрээлэн (KLRI)-тэй хамтарч Хуульчдын танхимд 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр "Солонгосын хууль зүйн судалгааны арга зүй" сэдвээр чадавхжуулах сургалт зохион байгуулсан. Тус сургалтад ХЗҮХ-ийн 23 судлаач, мэргэжилтэн,<br>Хууль зүйн үндэсний хүрээлэн, БНСУ-ын Хууль тогтоомжийн судалгааны хүрээлэн (KLRI)-ийн удирдлагууд болон төлөөлөгчдийн зөвлөлдөх уулзалтыг 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, сургалт, судалгааны чиглэлийн хамтын ажиллагааны талаар хэлэлцэж санал солилцсон. Уулзалтад нийт 10 хүн, нийт 33 хүн хамрагдсан. | 100 |
| 2.4.2. | Япон Улсын Хууль зүйн яамны харьяа Сургалт, судалгааны хүрээлэн(RTI)-тэй хамтарсан сургалт зохион байгуулах | Улсын төсөв, бусад эх үүсвэр | Сургалт хамтарч зохион байгуулсан байх | - | Сургалт 1 удаа зохион байгуулсан байх | ХЗҮХ, Япон Улсын Хууль зүйн яамны харьяа Сургалт, судалгааны хүрээлэн хооронд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрүүдэд Япон Улсад "Гэмт хэргийн цагаан номыг боловсруулах процесс", "Хууль тогтоомжийн мэдээллийн нэгдсэн сан", "Хуульчдыг мэргэшүүлэх сургалтын тогтолцоо" сэдвээр хамтарсан сургалт зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд тус хүрээлэнгийн захирал, ЦМОНХТ-ийн дарга, ЭШАА-ууд Япон улсад томилолтоор ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5. Эрх зүйн гол салбарт хийгдэж буй суурь судалгааны үр дүнг нэгтгэн жил бүр хэвлүүлэх | | | | | | | |
| 2.5.1. | Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2024 онд хийж гүйцэтгэсэн судалгааны тайланг эмхэтгэж хэвлүүлэх, нийтийн хүртээл болгох | Улсын төсөв | Судалгааны тайлангийн эмхэтгэл хэвлүүлэн олон нийтэд хүргэсэн байх. | 3 | 2 | Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2024 онд хийж гүйцэтгэсэн дараах судалгааны тайлангуудыг эмхэтгэн хэвлүүлж, холбогдох байгууллагад хүргүүлэн, ХЗҮХ-ийн цахим хуудас www.nli.gov.mn-т байршуулж, түгээж нийтийн хүртээл болгосон. Үүнд:<br>Нийтийн эрх зүйд холбогдох судалгааны тайлангийн эмхэтгэл XIX боть;<br>Эрүүгийн эрх зүйд холбогдох судалгааны тайлангийн эмхэтгэл XX боть;<br>Хувийн эрх зүйд холбогдох судалгааны тайлангийн эмхэтгэл XXI боть;<br>Судалгааны тайлангийн эмхэтгэл XXII боть (Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эрх зүйн зохицуулалтад холбогдох) | 100 |
| 2.6. Гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид, хуульчдын дунд хууль зүйн салбарын мэдээлэл солилцох, туршлага хуваалцах, мэтгэлцэх орчин бүрдүүлж, эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, семинар зохион байгуулах | | | | | | | |
| 2.6.1. | Олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах, оролцох | Улсын төсөв | Зохион байгуулсан, оролцсон олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, уулзалт, семинарын тоо | 18 | 18-аас доошгүй | Хууль зүй, дотоод хэргийн яам болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан "Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төслийн олон нийтэд зориулсан танилцуулга", "Эрх зүйн шинэтгэл II хөтөлбөр"-ийн хүрээнд "Хувийн эрх зүйн шинэтгэл, цаашдын чиг хандлага" зэрэг сэдвээр 12 хэлэлцүүлэг, Хүний эрхийн үндэсний комиссоос зохион байгуулсан 2024 оны сонгуулийн үеийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт", Хүний эрхийн үндэсний индекс тооцох аргачлалын төсөл танилцуулах, санал солилцох зэрэг 6, бусад байгууллагаас зохион байгуулсан "Монгол Улсын гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгох нь", "Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд ба төрийн эрх мэдлийн хяналт, тэнцвэр" зэрэг 15, нийт 32 хэлэлцүүлэгт, Филиппин улсын нийслэл Манила хотод зохион байгуулсан "Шударга ёсыг дахин төсөөлөх нь, "Хиймэл оюун ба эрх зүйн тогтолцоо", БНСУ-ын Сөүл хотноо зохион байгуулагдсан "Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд олон улсын хамтын ажиллагаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэхжүүлэх нь", Лаос улсын Вьентьян хотод зохион байгуулагдсан Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээ (ALIN) байгууллагын 21 дэх ээлжит чуулга уулзалт болон "Гамшигт тэсвэртэй Ази тив: Гамшгийн эрсдэлийн засаглалыг сайжруулах нь" зэрэг олон улсын 7 хурал, 3 сургалт, "Хүн төвт, пракматив төрийн үйлчилгээг хэрэгжүүлэх процессын дахин инженерчлэлийн удирдамж"-ийн төсөлд тусгагдсаны дагуу, зарим гадаад нэр томьёог монгол хэлнээ орчуулах асуудалд дэмжлэг үзүүлэх, "Иргэний хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх" ажилд дэмжлэг үзүүлэх зэрэг 5 уулзалт, уулзалтад тус хүрээлэнгийн захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, секторын эрхлэгч, эрдэм шинжилгээний ахлах ажилтан, ажилтнууд оролцсон.<br>Оролцсон хэлэлцүүлэг-33, олон улсын хурал-7, дотоод хурал-4, уулзалт-5, олон улсын сургалт-3, санамж бичиг байгуулсан-1, зохион байгуулсан арга хэмжээ 1, нийт 49 ажил арга хэмжээнд оролцсон | |
| 2.6.2. | Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаан зохион байгуулах | Улсын төсөв, бусад эх үүсвэр | Илтгэлийн уралдаан зохион байгуулсан эсэх | 1 | 1 | Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаан зохион байгуулах хүрээнд:<br>2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Б.Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг Хуульчдын танхимд зохион байгуулсан.<br>2025 онд зохион байгуулсан илтгэлийн уралдааны эмхэтгэлийг түгээсэн. | 100 |
| 2.6.3. | Үндсэн хуулийн цэцийн анхны дарга, гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совдын нэрэмжит хууль зүйн сэдэвт шилдэг өгүүлэл шалгаруулах уралдаан зохион байгуулах | Улсын төсөв | -Шилдэг өгүүлэл шалгаруулах уралдааныг зохион байгуулсан эсэх | 1 | 1 | Үндсэн хуулийн цэцийн анхны дарга, гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совдын нэрэмжит хууль зүйн сэдэвт шилдэг өгүүлэл шалгаруулах уралдаан зохион байгуулах хүрээнд:<br>Уралдаан зохион байгуулах бэлтгэл хангаж, шилдэг өгүүлэл шалгаруулах ажлыг хамтран зохион байгуулсан.<br>Шагнал гардуулах ёслолыг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн ордонд хамтран зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
